

АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 3-Р УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БИЧМЭЛ ТАЙЛАН

2024.10.02

Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар нь 3-р улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн биелэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд


Хүнс, худалдаа, нийтийн хоолны чиглэлээр

Улсын их хурлын "Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээний заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсөвт байгууллага болон нийтийн хоолны салбарын тогоочдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох Орон нутгийн онцлог бүхий уламжлалт бренд хоол, идээ ундааг шинээр бий болгох, хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор

"**ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ЭРҮҮЛ АХУЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ НЭВТРҮҮЛЭХ НЬ**" сургалт , Орон нутгийн бренд хоол , идээ, ундааны үзэсгэлэн, "Аймгийн аварга тогооч шалгаруулах уралдаан", спортын бүсчилсэн арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 13-15 ны өдрүүдэд тус аймгийн Сүхбаатар суманд амжилттай зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээнд Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Онгон, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумын **95** хоол үйлдвэрлэгч, хоол зүйч, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд оролцов.

Дээрх арга хэмжээг Ерөнхий зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хамтран зохион байгуулагч: Аймгийн Эрүүл мэндийн газар, Тогоочдын "Тулга" холбоо, Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газар төр, төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулсан ба тус газрын Үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга Б.Алтаннавч, Хяналтын албаны худалдаа, үйлдвэрийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Амарбат, хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч Э.Хандсүмбэрэл, Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Мөнхнаран, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Э.Сувд-Эрдэнэ нарын холбогдох мэргэжилтнүүд хоол үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг чадавхжуулах сургалтыг хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Жил бүр уламжлал болгон малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, аймгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Намрын ногоон өдрүүд- Сүхбаатарт үйлдвэрлэв-2024” арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс”, “Алтан намар”, “Хөнгөн үйлдвэрлэл”, “Шилмэл мал” үзэсгэлэн худалдаа Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо 2024 оны 9 дүгээр сарын 20-21 ний өдрүүдэд зохион байгуулж, тус арга хэмжээнд аймгийн 12 сумын 130 гаруй малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид оролцсон.

Орон нутгийн хувьд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд суурьлан хөгжих бодлого баримтлан орон нутгийн бренд бүтээгдэхүүн хөгжүүлэх хүрээнд 2024 онд олон ажил төлөвлөн хэрэгжүүлсний үр дүнд **“Миний өөшгөө” ХХК-ийн Дарьганга хийцтэй цай** бүтээгдэхүүний Дарьганга эхнэр, Эвхмэл

монгол бичиг бүхий Дарьганга хийцтэй цай, Дарьганга бренд гэсэн 3 зохиол барааны тэмдэгтийн патентын эрхээ баталгаажуулж, гэрчилгээгээ авсан. Үзэсгэлэн худалдаанд оролцогчдын бүтээгдэхүүн үйлчилгээг 10 номинациар шалгаруулж, сумын дүнгээр Баруун-Урт сум шалгарч шилжин явах цом, өргөмжлөл 700,0 мянган төгрөг, дэд байрыг Дарьганга сум эзэлж Өргөмжлөл, 500,0 мянган төгрөгөөр тус тус шагнагдсан байна.



Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, монголын Махны холбоо хамтран 2024 оны 9-р сарын 23, 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Мах, дотор махны өртгийн сүлжээг бэхжүүлэхэд мах,махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, технологийн хяналтын үүрэг” сэдэвт хэлэлцүүлэг, сургалтад нийслэлийн мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэрийн технологич, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэр хариуцсан мэргэжилтэн болон хүнс, худалдаа, мал эмнэлгийн байцаагч нарыг хамруулж, оролцогчдод сертификат гардууллаа.

Тус газрын дарга Т. Ган-Очир, ҮХҮА-ны дарга Б.Алтаннавч, Хяналтын албаны улсын ахлах байцаагч Т.Амарбат нар оролцсон.



“НАМРЫН НОГООН ӨДРҮҮД 2024” улсын үзэсгэлэн худалдааг 2024 оны 9 дүгээр сарын 23-29 хүртэлх хугацаанд зохион байгуулж, Төв цэнгэлдэх хүрээлэнд хүнсний боловсруулах салбарын 200 гаруй аж ахуйн нэгж, иргэн, хоршоо, 21 аймаг болон нийслэлийн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалагч 250 гаруй иргэн, хоршоо, аж ахуйн нэгж оролцож, бүтээгдэхүүнээ дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдэд шууд борлуулсан.

Энэ удаагийн “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээний онцлог нь аймаг, нийслэлийн болон нийт оролцогчдыг 7 бүсэд хувааж, бүс бүр нэг бүтэн өдөр арга хэмжээний тайзыг ашиглан өөрсдийн үйл ажиллагаа, тухайн бүс нутгийн онцлог, өв уламжлал, зан заншлыг таниулах, мөн бүс нутгийн онцлогийг шингээсэн шинэ болон брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах өдөрлөгийг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн арга хэмжээ боллоо.

Улсын үзэсгэлэн худалдаанд тус аймгийн Баруун-Урт сумын **“Миний өөшгөө”** ХХК-ний нутгийн брэнд бүтээгдэхүүн “Дарьганга хийцтэй цай”, “Хөмүүл”, “Таанын сорс”, Сүхбаатар сумын “Зараагийн буян овоо” ХХК-ны **сүү, сүүн бүтээгдэхүүн оролцож, 15,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.**





Газар тариалангийн чиглэлээр :

Газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу Газрын дарга ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч, Агрономич нар доорх ажлыг хийж гүйцэтгэсэн:

1. Хөнгөлөлттэй үнээр олгосон үрээр тариалалт хийсэн талбайн хэмжээ /га/
 2. Ургацын урьдчилсан баланс тогтоох.
 3. Орон нутгийн малчид, иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгох гэрээ, хэлцэл хийсэн баримт, нотолгоо.
 4. Ургамал, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах явцад ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх.
 5. Тариалангийн газарт агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэсэн, хөрсний үржил шимийг сайжруулсан эсэх.
 6. Хөрс боловсруулалт, уриншний төрөл, таримлын үрийн чанар, сорт, хадгалах агуулахын төрөл, хэмжээ, чанарт хяналт тавих.
 7. Газар тариалангийн үйлдвэрлэлд хэрэглэгдсэн пестицид, бордооны чанар аюулгүй байдалд хяналт тавих.
 8. Ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх явцад хяналт тавих.
 9. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нь өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын халдлага болон малаас хамгаалсан эсэх.
 10. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022оны А/196 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ургамал түүний гаралтай, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын 1.8, 2.12 дахь заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих.
- 9 сарын байдлаар намрын ургац хураалтад 7 үр тариа аж ахуй нэгж, 2 хоршоо, 213 тариаланч иргэн урац хураалт хийнэ. Ургац хураалтад 10 комбайн, 21 трактор, 22 дагалдах хэрэгсэл ажиллахаар байна. Ургац хураалтад байнгын 45 хүн, түр ажилтан 63 хүн 4 оюутан хамрагдаж байна. Улаан буудай 350 га-аас 210 тн Овьёос 185 га-аас 165 тн Төмс 14 га-аас 83 тн Хүнсний ногоо 9 га-аас 53 тн хураан аваад байна.





ЖДҮ, Хоршооны чиглэлээр:

Адапт төсөлтэй хамтран Төр ба хувийн хэвшлийн түншлэл 2024 сэдэвт зүүн бүсийн сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Сүхбаатар Дорнод аймгийн 70 гаруй хоршоодын төлөөлөл хамрагдсан. НҮБХХ-ийн хөтөлбөрийн шинжээч Х.Хишигжаргал сургалтыг нээж, ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Э.Сугарбаяр Засгийн газраас хоршоо, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хүнсний хангамжийг сайжруулах чиглэлээр баримталж буй бодлого чиглэл, Монголын махны холбооны гүйцэтгэх захирал Н.Батсуурь Мал аж ахуйн салбарын мах үйлдвэрлэлд зориулан шинэчлэх шаардлага, ХХААГ-ын дарга Т.Ган-Очир Зүүн бүсийн малын чанар, ашиг шимийн байдал, ноос ноолуур, мал мах бэлтгэх нөөц боломж, Адапт төслийн техникийн мэргэжилтэн П.Ганхуяг Үржлийн биотехнологийн арга ашиглан махны чиглэлийн үхэр, хонь үржүүлэх боломжууд сэдвээр илтгэл тавилаа. Мөн Сүхбаатар аймгийн Аздалгэр мөнх хоршооны дарга Э.Дуламсүрэн, Дорнод аймгийн Дашбалбар сумын “Сэвсүүл жараахайн булаг” хоршооны дарга Б.Батбаяр нар хоршооны сайн туршлагыг танилцуулсан.

Мал үржлийн ажлын чиглэлээр:

2024 оны 7-р сарын 10-11-ны өдрүүдэд аймгийн баяр наадмын өдрүүдээр албаны дарга мэргэжилтнүүд хурдан морины салбар комисст орж ажилласан.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ХХААГазартай байгуулсан “Засгийн газраас явуулж буй зудын дараах хэрэгцээ, шаардлагын үнэлгээг дэмжих зорилгоор зудад хамгийн хүндээр нэрвэгдсэн бүс нутаг болох Сүхбаатар аймгаас нарийн, тодорхой, найдвартай, төсөл хөтөлбөрт ашиглахуйц мэдээ, мэдээлэл цуглуулах ажил үйлчилгээ үзүүлэх тухай” гэрээний биелэлтыг хангах, мэдээ мэдээлэл малчдаас цуглуулах ажлаар 2024 оны 08-р сарын 9-ны өдрөөс 6 хоногийн хугацаанд ФАО-ын ажлын хэсэгтэй хамт 13 суманд очиж ажилласан.

Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн зааврын дагуу Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааны чихнээс дээж авах ажлыг 2024 оны 08-р сарын 29-30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааны цөм сүрэг байрласан Дөхөм, Дэлгэр, Баян, Хонгор багуудын 10 малчин өрхөөс 100 ямааны дээж цуглуулж, ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу зориулалтын хайрцаг саванд хийж битүүмжлэн мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнд хүргүүлсэн.



2024 оны 09-р сарын 4-7-ны өдрүүдэд НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын ажлын хэсэг манай аймагт ирж ажилласан. Энэ үеэр ХХААГ-ын дарга, МҮА-ны мэргэжилтэнүүдийн хамт өнгөрсөн өвлийн зудын улмаас хамгийн их хохирол амссан Сүхбаатар сумын малчдад “Сүхбаатар сумын мал аж ахуйн салбарын хохирол, хорогдол зудын нөлөөлөл” сэдвээр мэдээлэл хийж, илтгэл тавьсан.

Нийт 80 гаруй малчдад өнгөрсөн өвлийн зудын нөхцөл байдал, хохирол, хорогдол, цаашид авч хэрэгжүүлэх ажил, төрөөс баримтлаж буй бодлого, мал аж ахуйн салбарын цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэн, санал хүсэлтийг сонсон ажилласан.

9-р сарын 06-ны өдөр тус ажлын хэсэг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 13 сумын Засаг дарга, ХААТ-ын мэргэжилтэнүүд, багийн Засаг дарга нар, холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан өнгөрсөн өвлийн зудын

нөлөөлөл, хохиролын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийт 70 орчим хүн оролцсон.



2024 оны 09-р сарын 17-ны өдөр Түвшинширээ сумын “Алтан намар- эрүүл хүнс” үзэсгэлэн худалдаа, Малчдын гурван үеийн чуулга уулзалтанд оролцож “Сүхбаатар аймгийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр мэдээлэл хүргэж ажилласан. Уг чуулга уулзалтанд 85 орчим малчин хамрагдсан.



2024 оны 9-р сарын 20-21-ны өдрүүдэд Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв “Шилмэл малын 2024” үзэсгэлэн худалдааг Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотод зохион байгуулсан. Нийт 9 сумын 21 иргэн, 9 аж ахуй нэгжийн 130 гаруй толгой мал оролцсон. Уг үзэсгэлэн худалдаа нь Махны чиглэлийн үхэр, Сүүний чиглэлийн үхэр, Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааны хээлтэгч, хээлтүүлэгч гэсэн төрлөөр явагдсан. Төрөл тус бүр дээр тэргүүн, дэд, тусгай байр эзлүүлсэн. Гойд ашиг шимт малаар 16, тусгай байрын өргөмжлөлөөр 8 малыг шалгаруулж, медаль, өргөмжлөл, тууз, мөнгөн шагналыг гардуулсан.





Хяналтын ажлын чиглэлээр:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 08-00-02/03 дугаартай “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Аймгийн баяр наадмаар жижиглэн худалдааны чиглэлээр 19, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр 34, нийт 53 иргэн аж ахуй нэгжид зөвшөөрөл олгосон байна. Мөн 23 зөрчлийг илрүүлж газар дээр нь 9 буй 39.1 хувийг арилгуулж 15 аж ахуй нэгж, 38 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дүгээр сарын 13-ний өдрийн 03-00/13 дугаартай “Бүх шатын боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн

бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрэнд нийт 7 газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэх үеэр 33 зөрчлийг илрүүлж газар дээр нь 25 буй 75 хувийг газар дээр арилгуулж 45 албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-05/06 тоот удирдамжийн хүрээнд Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагчтай хамтран 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад 8 зөрчлийг илрүүлж, улсын ахлах байцаагчтай хамтарсан 23 заалт бүхий албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Мөн СУЕБ-ын баталсан “2024 онд тариалангийн үйлдвэрлэлийн технологи, хөрс хамгаалал, бордоо, ургамал хамгааллын бодисын чанар, импорт, хэрэглээ, зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 08-00-05/01 тоот удирдамжийн дагуу 7 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн. Шалгалтын явцад 30 зөрчлийг илрүүлэн ажиллав. 9 нэр төрлийн төмс, хүнсний ногооноос дээж авч СХЗГ-ын итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээнд хамрууллаа. Эерэг сорьц илрээгүй. Удирдамжийн хүрээнд 1 үр тарианаас дээж авч СХЗГ-ын ХАБҮЛЛ-д шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээний дүн гараагүй байна.

4. “Намрын ногоон өдрүүд Сүхбаатарт үйлдвэрлэв-2024” үзэсгэлэн худалдаанд нийт 12 сумын 131 иргэн аж ахуй нэгж үйлдвэрлэгчдийг хамруулан хяналт тавьж ажиллаа. Мөн Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-05/01 дугаар удирдамжийн хүрээнд 9 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд тус арга хэмжээнд оролцогч төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 15 иргэн, ААН-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад 11 зөрчлийг илрүүлэн газар дээр нь арилгуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн энэ улиралд нийт 195 өргөдөл гомдол, хүсэлт ирсэнээс 185 нь шийдвэрлэгдэж 10 өргөдөл гомдолын хугацаа болоогүй байна. Сар бүр ажилчдын хийсэн ажлын тайланг бичгээр хүлээн авч үр дүнг тооцон ажиллаж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН **Ө.ГАНЧИМЭГ**

